

Залуу хүмүүс гэдэг чинь —
 Хоёул гурвуул нийлээд
 Хоршоо сүлбээ байгуулаад
 Хуруу хумс хөдөлгөөд
 Хулгайлж явахыг хэлдэг биш
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Цааз хуулийг зөрчөөд
 «Цагаан бугуй»¹ зүүгээд
 Цагдаагийн газар суугаад
 Цагийг нөгцөөхийг хэлдэг биш.

Залуу хүмүүс гэдэг чинь —
 Саад бүхнийг даваад
 Саар бүхнийг тэвчээд
 Сайн бүхнийг сураад
 Сайшаагдаж явахыг хэлдэг юм.

1981—1—13
 Буулгасан **М. Зэнээ**

ТАНЫ МЭДЛЭГТ

БУДАЛИН ОРДОН

О. Оюунгэрэл
Л. Лхамдулам

Дэлхийд алдартай Буддын шашны тэргүүн Далай ламын ордон Будалинг Нарны хот Лхасын Марбори (Улаан уул) уулыг дамнуулан барьжээ. 13 давхар, 110 м өндөр энэхүү ордон зүүнээс баруун тийш 360 м сунаж байрласан нь Лхасын аль ч өнцгөөс бараа сүртэй сүндэрлэн харагдана. Будалин ордны санскрит дуудлага нь «Пудола», энэ нь буддын шашны Жанрайсэг бурхны онгон газар гэсэн үг. Энэхүү эртний барилга нь төвд үндэстний бүтээлч, хөдөлмөрч ард түмний бахархал болсоор иржээ.

Түүхэн сурвалжаас үзэхэд, Будалин ордныг манай эриний 641 онд Төвдийн хаан Соронзонгомбо хаан Тан улсын Тай Зун хааны Вэн Чэн гүнжийг хатнаа болгоход гүнжид зориулж барьсан байна. Марбори ууланд барьсан 999 байшин, мөн уулын орой дээрх олон давхар улаан орд бүхий нийт мянган барилгын цогцос нь Будалин ордны эх суурь болсон ажээ. IX зуунд Төвдийн феодал вангуудын хооронд болсон дайн дажны хөлд Будалин ордон өртөхөд ордны гэсэн зүйлүүдээс Төвдийн хаан Соронзонгомбо, Тан улсын Вэн Чэн гүнж, Балбын вангийн охин Чи Зун гүнжийн шавар баримал, хөргүүд л ойролцоох Фаван агуйгаас хожмоо олдсон байна.

Харин өнөө хүртэл сүндэрлэсээр буй Будалин ордныг XVII зууны эхээр V Далай лам дахин сэргээн бариулсан түүхтэй. V Далай ламыг бүх Төвдийн тэргүүн болоход нь түүний засгийн нэр хүндийг илтгэн харуулах үүднээс 1645 оноос ордныг сэргээх ажил эхэлжээ. 1653 онд шинэ Будалин ордны гол хэсгийг барьж дууссан тул Далай лам Брэвэн хийдээсээ уг ордонд шилжин суужээ.

Энэхүү сүрлэг ордон нь Улаан, Цагаан хоёр барилгаас бүрдэнэ. 4 давхар Цагаан ордныг нь 1659 онд барьж дууссан ба голын 9 давхар Улаан ордныг нь Төвдийн төрийн дээд сайд Санжа-жамцо (1653—1705) 1690—1694 онд V Далай ламын шарилыг байрлуулахаар бариулжээ.

Төвдийн түүх бичлэгт тэмдэглэн үлдээснээс үзэхэд Улаан ордныг сэргээн засварлахад хятад, монгол 50 гаруй алдар цуутай гар

1. Эмэгтэй хүний гоёл

урчуудыг урьж оролцуулсан гэдэг. Улаан ордонд нь хэдэн үеийн Далай ламын шарил, төрөл бүрийн бурхан тахилын өрөө байдаг бол Цагаан ордонд нь Далай лам амьдарч, шашин, улс төрийн үйл ажиллагаагаа явуулдаг байжээ. Эдгээр хоёр ордныг сэргээн барихад монголчууд хөрөнгө мөнгөө хандивлаж байсан нь анхаарал татах зүйл юм

Цагаан ордонд буй 48 баганатай Зүүн гол танхимыг 1645 онд барьжээ. Баяр наадам, шашны зан үйлийн ажиллагааг голлон явуулдаг Цагаан ордны хамгийн дээд хэсэгт Далай ламын өргөө байрлана. Өдөржин нарны гэрэл тусч байдаг тул түүний сууцыг Нарлаг (Личуан) танхим гэж нэрлэнэ. Баруун Нарлаг танхимыг ХШ Далай лам бариулж, Зүүн Нарлаг танхимд нь XIV Далай лам амьдарч байжээ.

Улаан ордон нь 8 суварга болон тахилгын танхимуудаас бүрдэнэ. Тэдгээрийн хамгийн анхны бөгөөд томыг нь V Далай ламд зориулан барьжээ. Уг танхим нь 50 баганатай, 680 хавтгай дөрвөлжин метр талбай эзлэх бөгөөд доторх ханы зургууд нь V Далай ламын үйл амьдралыг харуулна. Энэ танхимд төвд үндэстний түүх соёлын их өв хадгалагдаж байдгийн дотор Цин гүрний эзэн хаан Кан Сигаас (Энх-Амгалан) Далай ламд барьсан бэлгийн хоёр том хатгамал хивс бий.

Улаан ордны баруун өнцөгт ХШ Далай ламын 14 м урт 3 давхар суваргыг (түүний шарил буй) 1933—1936 онд барьж дуусгажээ. Түүнийг хаш болон элдэв зүйлийн эрдэнийн чулуугаар урлан бүтээсэн байна.

Нийтдээ 13 мянган хавтгай дөрвөлжин метр талбай газрыг эзлэх Будалин ордны тахиралдсан чулуун шатаар өгссөөр ордонд ороход юуны өмнө хуучны алдартай гар урчууд, дархчуудын уран гараар бүтсэн алд бүдүүн модон багана дээрх цэцгийн сийлбэр, таван өнгийн будгаар солонгоруулан зурсан ханын зургууд ордны доторх сүлжилдсэн урт тасалгаануудыг бүрхсэн нь нүднээ тусна. Будалин ордныг гаднаас харахад нүсэр том, лагс сүрлэг боловч дотор нь ороход хараа булаам гоёмсог, тоолж барамгүй олон ханын зураг төвдүүдийн «танка» (хөрөг) гэж нэрлэдэг зээгт наамлууд өлгөөтэй байх нь хараад ханашгүй. Зөвхөн Сысипинси хэмээх 2-р давхрын хонгилд 698 ханын зураг, үзмэрүүд байгаа нь дүрслэх урлагийн үзэсгэлэнгийн эртний үзмэрийн нэгэн танхимд орсон мэт санагдана. V Далай ламын түүх намтарт, Будалин ордны ханын зургийг Төвдийн өнцөг булангаас урьж ирүүлсэн 63 нэрт зураачид 1648 оноос эхлэн 10 гаруй жилийн турш зурсан тухай бичсэн байдаг. Түүнээс хойш 300 гаруй жилийн хугацаанд ханын зургууд олноор нэмэгджээ. Тэдгээрийн дотор өргөн нь 5—6 м, урт нь хэдэн арван метр зээгт наамлууд тааралдана. Будалин ордонд байдаг 30—40 метрийн урт Шагжамуни бурхны хөрөг нь ордны том хаалгыг бүрэн хаадаг байна.

Ордны дотор өвөрмөц чамин хийцээрээ олны анхаарал татахуйц том жижиг төрөл бүрийн гууль, алт, мөнгө, эрдэнийн чулуугаар хийсэн хэдэн зуун мянган бурхад бий. Тэдгээрийн зарим нь хэдэн метр хүрдэг бол зарим нь хуруун дайтай байх нь сонин. Будалин ордны барилга болон доторх тавилгад маш их алт, эрдэнэс орсон тухай олонтой бичсэн байдаг. Зөвхөн V Далай ламын шарилыг байрлуулсан өргөөнд 3720 кг алт зарцуулжээ.

Будалин ордны цогцолбор нь Төвдийн уламжлалт уран барилгын өнгө аясыг илтгэн харуулсан төвд үндэстэн ард түмний урлалын гайхамшигт бүтээл төдийгүй төвдүүдийн олон зуун жилийн соёлын өвийг хадгалсан үнэт сан, шашин, улс төрийн үйл ажилла-

гаанд холбогдох он цагийн өч төчнөөн үйл явдлуудыг гэрчлэх түүхийн чухал дурсгалт газар билээ.

БӨХИЙН НУТАГ ШИЛИЙН ГОЛ

М. Зэнээ

ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийг бөхийн өлгий нутаг гэж өвөр монголчууд ярих дуртай.

«Үдшээр гардаггүй цолмон од нь
Үүрийгээ цайхаар гялалзаад байна
Үзэмчин хошууны Дүүрэнзанаа

Үзүүлмээр, зайлмаар хаялаад байна...» гэсэн ардын дууг Өвөр Монголд дуулдаг. Дуунд гарч байгаа Дүүрэнзанаа бол Шилийн гол аймгийн алдарт бөх байсан билээ. Энэ алдарт бөхөө ард түмэн нь хайрлан магтаж, түүгээр бахархасан сэтгэлээ ардын дуундаа оруулан үеэс үед хүндэтгэн дуулж ирсэн нь энэ билээ.

Өвөр Монголд явагддаг Монгол бөхийн барилдаан нь БНМАУ-д барилдах үндэсний бөхтэй адил боловч өмсгөл, хийх мэх, унагах дүрэм зэргээр нэлээд өөр байдаг. Тухайлбал өвөр монгол бөхөд шуудаг байхгүй, түүний оронд буурны зогдор дууриалган хийсэн маш өргөн дээгүүрээ хуниастай олон нугалаа болсон өргөн өмд буюу туухуу өмсдөг. Зодог нь богино ханцуйтай, хоёр давхар булгаараар хийсэн, дээрээ гууль, мөнгөн товруутай, ар нуруун дээрээ дөрвөлжин тольтой байдаг. Өвөр Монгол бөх нь гараанд гарахдаа орсон буурын шогшоог дууриасан, үсэрч дэвхэрсэн байдалтай буурын шаваа дэвээг санагдуулам байдаг бол халх монголын бөхчүүд Хангарьд шувууны дэвэлтийг дууриасан байх жишээтэй. Өвөр Монгол бөх хөлөөр хөлд, гараар цээжинд мэх хийх бөгөөд гараар хөлд мэх хийдэггүй ба гар газар хүрвэл унасанд тооцно. Өвөр Монгол бөх товших, хавсрах, цохих, дэгээдэх, өсгийдэх, давхар хавсрах, тонгорох зэрэг мэх голлон хийдэг. Өвөр Монголд монгол үндэсний бөхөөс гадна самбо шиг барилдаж, оноогоор хождог хятад маягийн бөх гэх бас явагддаг.

Манжийн Чин улсын үед алдаршиж байсан сайн бөхчүүдийн нэг бол Шилийн голын үзэмчин зүүн бэйл хошууны Анчуу юм. Тэр Чин улсын их наадамд түрүүлж алдар нэрээ түүхэнд үлдээсэн байдаг. Анчууг залгасан олон сайн бөх төрсний дотор ихэд алдаршсан нь Баатарцогт, Дүүрэнзанаа, Багшийн-Улаан, Манх, Хархүүхэн, Готов, Арван зургаат Чойжамц, Борбаатар, Шарбаатар, Жаахан Нямаа, Янзган-Ёндон, Хотолбаяр, Хүрээ Баянцогт, Хүрээ Сэнгээ, Мөөхий Сэнгээ зэрэг бөхчүүд юм. Тэд аймаг хошуу, чуулганы наадамд олонтаа түрүүлж байсан дархан аврагууд билээ.

Нутгийн настайчуудын ярихаар бол Багшийн-Улаан гэдэг бөх өвдөг шороодож үзээгүй гэдэг. Ийм бөхийг нутгийнхан «туухуу зодогт нь тоос хүрч үзээгүй бөх» гэж ярилцдаг байна.

Өвөр Монгол бөхчүүд өөр нутаг усанд очиж барилдахдаа Чингисийн үеийн алдарт бөх Бэлгүүтэйн бөхийн хэрэглэл хадгалсан хэмээх газар очиж мөргөн биеэ даатгадаг байсан уламжлалтай. Энэ